

ТӨВ АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ БА ГУРВАН ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА (МОНГОЛ, ОРОС, ХЯТАД)

К.Дэмбэрэл*

Төв Азийн аюулгүй байдлын асуудлыг нэгдүгээрт, дэлхийн аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг, хоёрдугаарт, энэ бүс нутагт Монгол Улс мөн түүнчлэн ОХУ, БНХАУ-ын муж, бүгд найрамдах улсууд, автономит районуд шууд хиллэн оршдог гэдгээр нь авч үзэх нь зүйтэй. Манай 3 улсын бүс нутгийн бодлогын хүрээнд Төв Азийн аюулгүй байдлын асуудал нь гурван талын төдийгүй олон талын хамтын ажиллагаа шаардсан асуудлын нэг. ОХУ, БНХАУ-ын олон субъектууд Монгол Улстай шууд хил залгаа оршиж байгаа явдал нь гурван улсыг шууд болон шууд бус замаар бүс нутгийн аюулгүй байдлыг хангах асуудалд татан оруулж байна. Тиймээс энэ өгүүлэлд аюулгүй байдлыг хангахад улс бүрийн санал, санаачилга чухал гэдгийг харуулахыг зорилгоо.

Төв Ази: газар зүйн болон геополитикийн ойлголт болох нь

Төв Ази гэдэг нь газарзүйн хувьд уртрагийн дагуу Хар далайн зүүн эргээс Хянганы нуруу хүртэлхи, өргөргийн дагуу Сибирийн ойт хээрээс Ираны өндөрлөгүүд хүртэлхи эртний түрэг, монгол угсааны нүүдэлчдийн өлгий нутаг.

Төв Ази нь газар зүйн ойлголтын хувьд хоёр зуу орчим жил болсон. Харин геополитикт “Төв Ази” болон “Дотоод Ази” гэсэн ойлголт үүсээд бас л зуун тавь шахам жил болсон. Төв Ази нь харилцан нөлөөлөл бүхий улс орнууд болон бүс нутгийн уулзварт оршдог өвөрмөц бүс нутаг. 1990-ээд оны эхээр Дундад Азийн БНУ-уд тусгаар тогтнож, бүс нутгаа “Төв Ази”-ийн хэмээн тодорхойлсон. Сонгодог томъёоллоо дагавал энэ ч бас учир дутагдалтай томъёолол болсон.

“Төв Ази”-д Дундад Азийн БНУ-уд, Ираны хойд мужууд, Афганистан, БНХАУ-ын ШҮӨЗО, ӨМӨЗО, Түвд, ОХУ-ын өмнөд Сибирийн мужууд, Волга хавийн зарим муж болон Монгол Улсыг багтаасан бүс нутаг хамрагдаж байгаа юм.



* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Энэ өгүүлэлд “Дотоод Ази”-д /Шукина Н.М. Как создавалась карта Центральной Азии. М., 1955/ Монгол, Казахстан, Кыргызстанаас гадна ОХУ-ын Буриад, Тува, Алтай, Хакасын БНУ-уд, БНХАУ-ын Өвөр Монгол, Шинжаан, Түвд, Манжуурыг хамруулсан болно.



Дотоод Азийн аюулгүй байдлыг хангах талаархи гурван улсын хамтын ажиллагаа нь Төв Азид аюулгүй байдлыг хангахад чухал хүчин зүйлийн нэг мөн. Төв Азийн аюулгүй байдлын асуудлууд нь Дотоод Азийн тогтвортой хөгжил, аюулгүй байдлын салшгүй хэсэг гэдэг утгаар нь үзүүлэх нөлөө, цар хүрээ, үүсч болох үр дагаврын талаас нь судлах ёстой. Өөрөөр хэлбэл, Төв Азид үүссэн асуудлыг судлахгүйгээр Дотоод Азийн асуудлыг ярина гэдэг учир дутагдалтай зүйл.

Төв Азийн аюулгүй байдлын асуудлууд нь “Төв Азийн геополитик ба Монгол Улс” номонд илүү дэлгэрэнгүй тусгагдсан тул энэ өгүүлэлд давтаж нуршсангүй. Харин Дотоод Азийн аюулгүй байдлын талаар илүү дэлгэрэнгүй өгүүлж байна.

Дотоод Ази ба ОХУ

Дотоод Азид ОХУ-ын дараахи субъектууд багтдаг. Үүнд: Алтай, Красноярск, Кемеров, Эрхүү, Чита мужууд болон үндэсний цөөнхийн улсууд болох БНАлтай улс, БНХакас улс, БНТува улс, БНБуриад улс ордог. Орост газар зүйн хувьд дээрхи орон зайг бүхэлд нь Сибирь гэдэг. Түүнчлэн, Челябинск, Оренбург, Новосибирск, Курган мужуудыг оруулах шаардлагатай хэмээн судлаачийн хувьд үздэг.

Сибирь, Монгол, Хятад, Дундад Азийн эдийн засгийн харилцаа эртнээс үүсч бий болсон олон зууны баялаг түүхтэй. Тухайлбал, 1917-1991 онуудад Сибирь, Монгол, Дундад Ази, 1920-1940 онуудад Сибирь, Монгол, Дорнод Түркестан буюу одоогийн БНХАУ-ын

ШУӨЗО, Дундад Ази нь улс ардын аж ахуйн нэг цогц бүс нутгийн хүрээнд хөгжиж байлаа.

Дотоод Азид хамаарах ОХУ-ын субъектууд

№	Субъектын нэр	Газар нутаг (мян.хав.дөр.км)	Хүн ам (сая хүн)
1	БНБуриад улс	351,3	1
2	БНТува улс	170,5	0,3
3	БНАлтай улс	92,6	0,2
4	БНХакас улс	61,9	0,6
5	Чита	431,5	1,3
6	Кемеров	95,5	3
7	Эрхүү	400	2,6
8	Красноярскийн хязгаар	140	3,2
9	Алтайн хязгаар	261,7	2,7
	Нийт	1817	14,7

Монгол Улстай шууд хиллэдэг үндэсний БНУ-удад амьдардаг алтайчууд, хакасчууд, тувачууд, буриадчууд нь монголчуудтай хэл соёл, угсаа гарвал нэгийн хувьд нийтлэг зүйл олон.

Монгол, Казахстан, Кыргызстанд болж буй бүхий үйл явц БНАлтай улс, БНХакас улс, БНТува улс, БНБуриад улс зэрэг ОХУ-ын үндэсний цөөнхийн субъектуудад төдийгүй БНХАУ-ын ШУӨЗО, ӨМӨЗО зэрэгт шууд нөлөөлөх ба эсрэг урсгал ч байх боломжтой. Жишээлбэл, БНАлтай улсын нэг районд гэхэд 12 мянган казахууд оршин суудаг ба тэд хөрш Казахстан улсын талаар байнга анхаарч, сонирхож байдаг. Энэ нь Төв Азийн асуудал Дотоод Азид шууд нөлөөлнө гэсэн баталгаа.

БНАлтай улс, БНХакас улс, БНТува улс, БНБуриад улсуудад түгээмэл байгаа ба тухайн субъектуудын аюулгүй байдалд шууд нөлөөлөхүйц ингэснээрээ Төв Азийн аюулгүй байдал, тогтвортой хөгжилд сөрөг үр дагавар бий болгож болохуйц зүйлээс дурдвал:

- дундаж наслалт бага байгаа (эрэгтэй – 56.87, эмэгтэй – 63.45);
- эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн харьцааны алдагдалт;
- шилжилт хөдөлгөөн их байгаа;
- хөдөөгийн хүн ам ихтэй (62.8%);
- хүүхдийн эндэгдэл их;
- ажилгүйдэл ихтэй;
- боловсролын түвшин доогуур;
- зах зээлээс хол;
- аж үйлдвэрийн томоохон объект байхгүй;
- хөдөлмөрийн хөлс бага

Эдгээр нь нийгэмд тогтворгүй байдал бий болгох, түүнчлэн Төв Азид “газар аваад” байгаа “З-изм” буюу терроризм, экстремизм, сепаратизмыг Дотоод Азид дэлгэрэх үндэс суурь болоход нөлөөлнө.

Тиймээс ОХУ-ын төв засгийн зүгээс дараахи арга хэмжээг авч явуулбал тогтвортой байдлыг хангах урьдчилсан арга хэмжээ болно. Үүнд:

- ЗХУ-ын үеэс авч хэрэгжүүлж байсан “үйлдвэржүүлэх” бодлогоо орчин үеийн нөхцөлд шинээр авч үзэх;
- ОХУ-ын Холбооны хурал, Төрийн Думд үндэсний цөөнхийг тухайн үндэстний төлөөллөөр хангах;
- Субъектуудын эдийн эрх чөлөөг нэмэгдүүлэх;
- Субъектуудын боловсролын салбарыг;
- Субъектуудын эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Дэд бүтцийн хөгжлийг сайжруулах;
- Хэл соёл, угсаа гарвал нэг ард түмнүүдийн соёлын харилцааг өргөжүүлэх

ОХУ-ын төв засгийн зүгээс үндэсний субъектуудад онцгой анхаарал хандуулах, арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь бүс нутгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжилд тухайн улсын оруулж буй бодит хувь нэмэр хэмээн үзэх үндэстэй.

Дотоод Ази ба БНХАУ

Дотоод Азид газар зүйн хувьд БНХАУ-ын дараахи субъектууд багтдаг. Үүнд: Цинхай, Ганьсу, Өвөр Монголын өөртөө засах орон (ӨМӨЗО), Шинжаан уйгурын өөртөө засах орон (ШУӨЗО), Түвд. Энэ бүс нутгийг хятадын ном зүйд “баруун хязгаар” хэмээн тэмдэглэж ирсэн. Монгол, түвд, уйгур зонхилон амьдардаг энэ бүс нутаг бол Дотоод Азийн төдийгүй Төв Азийн аюулгүй байдалд онцгой байр суурьтай бүс нутаг.

Дотоод Азид хамаарах БНХАУ-ын субъектууд


№	Субъектын нэр	Газар нутаг (мян.хав.дөр.км)	Хүн ам (сая хүн)
1	Цинхай	720	4,07
2	ӨМӨЗО	1183	20,07
3	Ганьсу	450	20,41
4	ШУӨЗО	1600	13,61
5	Түвд	1220	1,99
	Нийт	5173	60,1

Судлаачийн хувьд үзэхэд ШУӨЗО нь судалгааны асар их боломжтой субъект. Төв Ази болон Дотоод Азид шууд хамааралтай, олон үндэстний, байгалийн арвин нөөцтэй, эдийн засгийн хөгжлийн гараан дээр байгаа хэдий ч шашин хоорондын зөрчилтэй, салан тусгаарлах үзэл санаа хүчтэй хөгжсөн субъект. ШУӨЗО нь Казахстан, Кыргызстан, Тажикистан, Пакистан, Афганистан, Монгол, ОХУ, Энэтхэг гэсэн улсуудтай шууд хиллэдэг. БНХАУ-ын эдийн засгийн

нээлттэй бодлогод 1992 оноос “хамрагдсан”, 120 төрлийн эрдэс түүхий эдийн баялагтай, үүнээс 20 бүх Хятадын хэмжээнд нөөцөөрөө нэгдүгээрт бичигддэг. ШУӨЗО нь Баруун, Зүүн, Өмнөд, Хойд гэсэн 4 бүсэд хуваагддаг.

Баруун болон Өмнөд бүсэд салан тусгаарлах үзэл санаа ихэд хөгжсөн, исламын үзэл санаа, уламжлал хэвээр хадгалагдсан, энэтхэг, пакистан, дундад азийн нөлөө чухал үүрэгтэй байдаг. ШУӨЗО-д 47 үндэстэн аж төрдөг ба хамгийн томоохон нь уйгурууд буюу 9 сая илүүтэй. Мөн 100 орчим монгол овогтон аж төрдөг. Нийт хүн амын 60% нь исламын шашин шүтдэг, 0,8 хувь нь шарын шашинтай.

Приложение 4-3.



ШУӨЗО-ны Засаг захиргааны хуваарь

БНХАУ үүссэн цагаас ШУӨЗО-д салан тусгаарлах үзэл санаа идэвхжээр ирсэн. 1990-ээд оноос энэ үйл явц улам эрчимжсэн нь БНХАУ-ын бүрэн бүтэн байдалд заналхийлах хэмжээнд хүрсэн. Тиймээс Хятадын төв засгаас эдийн засгийн шинжтэй арга хэмжээг идэвхжүүлсэн.

Бүс нутгийн хэмжээнд аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг бий болгоход анхаарч үзэх зүйлээс:

- ШУӨЗО-ны геополитикийн ач холбогдлыг нэмэгдүүлэх;
- Хил дамнасан гол, горхи усны асуудлыг үр өгөөжтэй ашиглах;
- Дундад Азийн орнууд, ОХУ, Монгол Улстай эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх;
- Бүс нутагт Хятадад төдийгүй олон улсын хэмжээнд гарч чадах хүчин чадалтай томоохон үйлдвэр аж ахуйн газруудыг барьж байгуулах;
- Дотоод Азийн хүрээнд ОХУ-ын болон БНХАУ-ын үндэсний субъектуудын хоорондын харилцааг дэмжин хөгжүүлэх;

- Үндэсний субъектуудад уламжлалт амьдралын хэв маягаа хадгалах, үндэсний хэл, соёлоо хөгжүүлэхэд дэмжин туслах;
- Бүс нутагт гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих;
- Төв засгийн зүгээс шашны талаар баримтлах бодлогоо чангатгахгүй байх;
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдлыг субъектуудад гаргуулахгүй байх;
- Байгаль орчин, экологийн асуудлалд онцгой хяналт тавих;
- Цөмийн шаарыг бүс нутагт булшлах асуудлыг зогсоох;
- Бүс нутагт шүтэх бишрэх ёсны талаар баримтлаж ирсэн зарчмаа өөрчлөхгүй байх;
- Бүс нутагт төрөлтийг дэмжих.

БНХАУ-ын зүгээс Төв Азид явуулах бодлогын үндсэн чиглэлүүд буюу Төв Ази дахь Хятадын сонирхол.

- ШУӨЗО дахь салан тусгаарлах үзэл санааг саармагжуулах, сарниулах;
- Төв Азийг стратегийн хувьд найдвартай ар тал болгон хувиргах;
- Бүс нутгийн эрчим хүчний эх сурвалжид хүрэх эрхтэй болох;
- Бүс нутгийн улсуудтай найрсаг хамтын ажиллагааг бий болгох;
- Бүс нутгийн орнуудын эдийн засгийн хөгжилцэцэглэлтийг дэмжих;
- Хятадын эсрэг чиглэсэн аливаа цэргийн эвсэл бүс нутаг бий болохоос урьдчилан сэргийлэх;
- Терроризмын эсрэг тэмцэх үр ашигтай механизм бий болгох.

Дотоод Ази ба Монгол Улс

Төв Азийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн төлөө Монгол Улс өөрөөс хамаарах бүхий л зүйлд санаачилгатай оролцож ирсэн. Тухайлбал, Иракт цэргээ илгээх, Афганистанд сургагч нараа явуулах, ШХАБ-д ажиглагчаар оролцох, өөрийн нутаг дэвсгэрээ цөмийн зэвсгээс ангид байлгах гэх зэргээр идэвхтэй ажилласаар байна.

Төв Азид өргөн уудам нутагт тархан суусан хэл,соёл, угсаа гарвал нэгт ард түмнүүдтэй харилцан өргөн хүрээнд хамтран ажиллах, уламжлалт соёлоо хэвээр авч үлдэх нь Монгол Улсын язгуур эрх ашгийн нэг. Энэ сонирхлоо Дотоод Азид түлхүү илэрхийлэх үүрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхдээ ОХУ, БНХАУ-тай хамтран нийтлэг эрх ашгаа хамгаалж, бүс нутгийн тогтвортой хөгжлийн төлөө байгаа гэдгээ бүрэн ойлголцож ирсэн.

Бүс нутгийн хамтын ажиллагаанд Казахстан, Кыргызстантай тогтоосон харилцаа чухал байр суурийг эзэлдэг. ОХУ, БНХАУ-тай тогтоосон харилцаанд тэдгээрийн хил орчмын субъектуудтай тогтоосон харилцаа хамтын ажиллагаа онцгой байр суурьтай. Нэн ялангуяа, эдийн засаг, соёлын хүрээнд илүү ахицтай байгаа.

Төв Азид аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад Монгол Улс үлгэр жишээ болохуйц давуу талыг харуулах боломжтой. Тухайлбал:

- хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэж ирсэн
- эдийн засгийн харьцангуй нээлттэй улс болж чадсан
- хөрш орнуудтайгаа хил хязгаарын маргаангүй бөгөөд баталгаатай болгож чадсан
- хүн амын 94% нь буддын шашинтай буюу шашин хоорондын мөргөлдөөний асуудалгүй улс
- нэгдмэл нэг угсаатан тул угсаатан хоорондын зөрчил байхгүй
- хөгжилтэй орнуудын зохих эрх ашгийг өөртөө төвлөрүүлж, хүчний харьцааг онцгой анхаардаг
- нүүдлийн соёл иргэншлээ хадгалан үлдэж чадсан улс
- олон улсын чанартай аливаа маргааныг яриа хэлэлцээрийн замаар аль эсвэл НҮБ-ын хүрээнд зөв зохистой шийдэхийн төлөө байдаг.

Дүгнэлт

ОХУ болон БНХАУ-ын бүс нутгийн бодлогод олон улсын терроризм, шашны хэт даврагчдын зүгээс үүсэх аюулыг саармагжуулах асуудал голлодог. Аль аль нь энэ бүс нутагт аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг дэмжих, Төв Азийг салан тусгаарлалт, терроризм, шашны хэт даврагсдын үйл ажиллагааны талбар болгохыг таслан зогсоох нийтлэг зорилготой байгаа. Дээрхи чиглэлд хоёр улсын хамтын ажиллагаа зөвхөн хоёр талын төдийгүй ШХАБ-ын хүрээнд идэвхтэй өрнөж байна.

Өнөөдөр дэлхий дахины эрчим хүчний хомсдлын улмаас “стандарт” бус нөхцөл байдал үүсээд байна. Төв Азид ч Дотоод Азид ч ялгаагүй газрын тос, байгалийн хий, байгалийн эрдэс түүхий эд, ашигт малтмал нь тухайн бүс нутгийн аюулгүй байдлын баталгаа болох нэг талтай ч, бүс нутгийн аюулгүй байдлыг тогтворгүйжүүлэх хоёрдогч функцыг ч давхар гүйцэтгэж байна. Бүс нутгийн орнуудын хувьд энэ хоёрын алтан дундажийг олох гэж нэлээд “халуун” үйл явдал болсоор байгаа.

ОХУ болон БНХАУ-ын бүс нутгийн аюулгүй байдлын талаархи стратегийн сонирхол бол аюулын “голомт” шинээр бий болгохгүй байх явдал. Монгол Улсын хувьд бол түүний эргэн тойрон хил залгаа оршин байгаа хоёр хөршийн субъектуудад тогтвортой хөгжил, найрсаг харилцаа зонхилсон байж хэл, соёл, уламжлалт зан заншлаа хадгалан хамтдаа хөгжихийг эрхэмлэж байгаа. Нэн ялангуяа, ШҮӨЗО, ӨМӨЗО-той олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь хөрш улсуудын хувьд зайлшгүй зүйл мөн. Гурван талын хамтын ажиллагаа нь Дотоод Азийн тогтвортой хөгжил, аюулгүй байдлыг хангах чухал хүчин зүйл. Энэ өгүүлэлд байнга “тогтвортой хөгжил” гэсэн нэр томъёог хэрэглэж

байгаа нь бүс нутгийн аюулгүй байдлын нэг эх сурвалж нь хөгжлийн хоцрогдол тул зайлшгүй хэрэглэхэд хүргэсэн.

Хөрш орны субъектуудын тогтвортой хөгжил, тэдгээрийн аюулгүй байдлын асуудал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлнө. Тиймээс хамтын ажиллагааны олон хэлбэрийг хослуулж болно. Тухайлбал, ШУӨЗО, Алтайн БНУ, Алтайн хязгаар, Монголын баруун талын 3 аймгийг Дорнод Казахстантай холбон бүсчилж хөгжүүлэх, зам харилцааг сайжруулах талаар засгийн газрын хэмжээнд яригдсан төслүүдийг хэрэгжүүлэх эхлэх нь чухал.

Хоёр хөршийн хувьд Дотоод Азид багтах үндэсний субъектууд руугаа хандсан алсын хараатай зөв бодлого явуулах нь Төв Азийн аюулгүй байдлыг хангах чухал хүчин зүйл мөн.